

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч, Адъяа Мэнхсайхан

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах, төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, төслийн бүрэн шинжилгээг хянах, дүгнэх, төслийн сонгон шалгаруулалт болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, түншлэлээр хэрэгжсэн төслийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг удирдан зохион байгуулна.							
1	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагалдан гарах журам, аргачлалд заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хэрэгжилтийн явц, хувиар	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан.	Холбогдох журам, аргачлалд заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажилласан байна. /100 хувь/	- Монгол Улсын Их Хурлаас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, Нийслэл болон улсын төсвөөс сүүлийн 3 жил дараалан санхүүгийн дэмжлэг аваагүй, эсхүл 100,000, түүнээс дээш хүн амтай аймгууд бие даан түншлэлийн төслийг тодорхой салбарт хэрэгжүүлэх боломжтой болсон. Тус хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу Нийслэлийн засаг даргаас "Түншлэлийн төслийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%



урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх журам”, “Хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам”, “Түншлэлийн гэрээ байгуулах, хэлэлцээ хийж сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулах журам”, “Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам”-ыг батлуулахаар Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох материалын хамт ирүүлснийг Засгийн газрын хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллалаа. 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар тус журмуудын төслийг хэлэлцэн баталсан.

- Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам төсөл”-ийн түншлэлийн төслийн саналыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон дагалдан гарсан журам, аргачлал заасны дагуу хүлээн авч, урьдчилсан үнэлгээг Зам, тээврийн яамтай хамтран хийж, Сангийн яамаар хянуулан, тус төслийн бүрэн

					шинжилгээний багийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, холбогдох журмын талаар төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн зарим албан тушаалтнуудад тогтмол мэдээллийг хуулийн хүрээнд өгч ажиллаж байна.		
2	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон тус хуулийг дагалдан гарсан журам, аргачлалын хүрээнд сургалтыг зохион байгуулна.	Сургалт зохион байгуулсан тоо .	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан.	Холбогдох байгууллагуудад нийт 3-ас доошгүй удаа сургалт орсон байна.	2024 оны 04, 08 дугаар саруудад Зам, тээврийн яам, 2024 оны 06 дугаар сард Эрчим хүчний яам, 2024 оны 07 дугаар сард Боловсролын яамны зарим албан хаагчтай уулзалт хийж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон дагалдан гарсан журам, аргачлалын талаар сургалт орж, мэдээлэл өгсөн. Зарим салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад утсаар хууль болон журмын талаарх мэдээллийг тогтмол өгч байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв байгуулах бэлтгэл ажлыг хангаж	Хэрэгжилтийн явц, хувиар	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв байгуулах бэлтгэл ажлыг хангаж	- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар Түншлэлийн төвийг байгуулах хүртэл уг төвийн чиг үүргийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	100%

	ажиллана.			ажилласан байна. /100 хувь/	хэрэгжүүлнэ гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн төслийн саналын урьдчилсан үнэлгээний бүрэлдэхүүнд ажиллан, холбогдох дүгнэлтийг гаргасан. Мөн Эдийн засаг, хөгжлийн яам Түншлэлийн төвийн чиг Үргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зөвлөх сонгон шалгаруулах, бараа материал худалдан авах үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулж, уг үнэлгээний хороонд орж ажилласан. - Засгийн газрын 2024 оны 23 дугаар тогтоолоор "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг баталсан.	сар, 11-р сар, 12-р сар	
4	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр салбар яамдаас ирүүлсэн саналыг ТХХТ-ийн хуульд заасны дагуу судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллана.	Хэрэгжилтийн явц, хувиар	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан.	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр салбар яамдаас ирүүлсэн саналыг ТХХТ-ийн хуульд заасны дагуу судлан, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	Зам, тээврийн хөгжлийн сайдас 2024 оны 01/1121 дугаар албан бичгээр "Эссенз саплайз" ХХК-аас гаргасан "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам төсөл"-ийн саналд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан урьдчилсан үнэлгээ хийлгүүлэх" хүсэлт ирүүлсэн. Үүний дагуу Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

5	Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин ажиллаж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.	Хэрэгжилтийн явц, хувиар	Концессын гэрээний хэрэгжилтийн явцад тухай бүр хяналт тавьсан.	Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин ажиллаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. /100 хувь/	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд зааснаар Эдийн засаг, хөгжлийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам хамтран Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 19, 22 дугаар зүйл болон “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам”-ын дагуу урьдчилсан үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/264 дугаар тушаалаар тус төслийн бүрэн шинжилгээг хийх төслийн багийг байгуулж, тус багийн бүрэлдэхүүнд орон ажиллаж байна.	Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин ажиллаж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд: - Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам төсөл: Төслийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаад байна. - Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар 100%

чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км авто зам төсөл: Төслийн концесс эзэмшигч "Ундрах говь" ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг судлан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тус яам Засгийн газрын хуралдаанд танилцуулан, Засгийн газраар хуралдаанаар хэлэлцэн, Засгийн газрын 2024 оны 108 дугаар тогтоолоор концессын гэрээнд холбогдох өөрчлөлт оруулах зөвшөөрлийг Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад зөвшөөрөөд байна. - Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл: Төслийн концесс эзэмшигч "Макс рөүд" ХХК-аас шүүхэд гаргасан нэхэмжлэлийн дагуу хариу тайлбар, холбогдох материал, мэдээллийг Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Должинсүрэнтэй хамтран гаргасан. - Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төсөл болон бусад төслүүний ажлыг

					эрчимжүүлэх талаар холбогдох албан тоот, мэдээллийг концесс эзэмшигч болон зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгжид удаа дараа өгсөн.			
6	Монгол Улсын 2024 оны төсөвт батлагдсан концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлсэн төслүүдийн санхүүжилтийг хууль, гэрээ, аудитын дүгнэлтэд нийцүүлэн шийдвэрлэнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	Монгол Улсын 2023 оны төсөвт төслийн санхүүжилт батлагдсан.	Монгол Улсын 2023 оны төсөвт 4	Улсын төсөвт батлагдсан санхүүжилтийг хууль, гэрээ, аудитын дүгнэлтэд нийцүүлэн шийдвэрлэсэн байна. /100 хувь/	Монгол Улсын Дээд шүүхийн Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 001/ХТ2024/00103 дугаар тогтоолоор нэхэмжлэгч "Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концесс эзэмшигч "Макс рөүд" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, Засгийн газраас 10,928,624,101 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжид 54,801,071 төгрөг, нийт 10,983,425,172 төгрөгийг гаруулахаар шийдвэрлэсэн. Монгол Улсын Дээд шүүхийн Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол гарсан байгаатай холбогдуулан концесс эзэмшигч "Макс рөүд" ХХК-д олгох төлбөрийг 2025 оны улсын төсөвт Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад суулгах арга хэмжээ авах тухай хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

7	Нэгжийн эрхлэх чигүүргийн хүрээний асуудлаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хяналт тавина.	Хэрэгжилтийн явц, хувиар	Засгийн газрын 2024 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан.	Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт хангагдсан байна./100 хувь/	<p>- "Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам"-ын 1.3-т заасны дагуу тус яам "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлыг сонгон шалгаруулах ажлын хэсэг, захирлын ажлын байрны тодорхойлолт, сонгон шалгаруулах удирдамжийг баталж, ажлын хэсгээс Түншлэлийн төвийн захирлыг сонгосон дүгнэлт гаргаж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тус дүгнэлтийг хүргүүлснээр тус төвийн захирал томилогдоод байна.</p> <p>- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагаатай холбоотойгоор тус төвийн албан хаагчдыг хуулийн хүрээнд тогтмол мэдээллээр ханган ажиллаж байна.</p>	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	--------------------------	--	--	--	------------------------------	------

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	5		
1	2	3	4	6	7			
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх								
1	Өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх.	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх.	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна.	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна.	Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулдаг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалт"-д суусан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%	
2	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх.	Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх.	Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна.	Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна.	Яамнаас зохион байгуулж буй мэдээллийн цагт тогтмол хамрагдаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч, Адъяа Мөнхсайхан
 /.....
 Огноо: ...2024.12.16.....